

2026 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДРИЙН  
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ  
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

2026-01-19

Өндөртолгой

Нийслэл, дүүргийн шуурхайн үүргийн биелэлтийг Агил-11, 12 фонтоор бичиж, **2026 оны 01 дүгээр сарын 27-ны “Мягмар” гарагт 12.00 цагт Засаг даргын Тамгын газрын холбогдох бодлогын хэлтэст албан бичгээр, Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсүүд 16.00 цагт** Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Эрх зүй, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн (ERP Н.Батцэнгэл)-д word файлаар ирүүлнэ үү.

Нийслэл, дүүргийн удирдлагаас цаг үеийн холбогдолтой өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг ирүүлэхдээ Нийслэлийн Хяналт-шинжилгээ үнэлгээний газраас ирүүлсэн “Зөвлөмж хүргүүлэх тухай” 2025 оны 44 дүгээр зөвлөмжийн дагуу дараах шаардлагыг ханган тайлагнаж ажиллана уу.

1. Хэрэгжилтийг 2000 тэмдэгтэд багтаан тайлагнах, үйл ажиллагааны явц бус гарц, үр дүнг тайлагнах.

2. Үүргийн биелэлтийг тогтоосон хугацаанд, нотлох баримтын хамт, бүрэн гүйцэд тайлагнах.

3. Хамтран хэрэгжүүлэгч байгууллага бус үндсэн буюу бодлого хэрэгжүүлэгч байгууллага нэгтгэн тайлагнах гэсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
<b>НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР</b>		
1.	Сурагчдын амралт дуусаж байгаатай холбогдуулан дараах ажлуудыг зохион байгуулах. Үүнд: - Сургууль, цэцэрлэгийн орчны аюулгүй байдлыг хангаж, болзошгүй зөрчлөөс урьдчилан сэргийлэх; - Замын хөдөлгөөний зохицуулалтаа сайтар зохион байгуулах; - Сүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг сайтар хангаж, танилцуулах; - Эрүүл мэндийн үзлэгүүдийг зохион байгуулах.	Нийгмийн хөгжлийн хэлтэс, Боловсролын хэлтэс, Эрүүл мэндийн төв, Цагдаагийн хэлтэс
2.	Хийн түлшний шилжилт болон түүний аюулгүй байдлыг сайтар хангаж ажиллах.	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Онцгой байдлын хэлтэс
3.	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын хүрээнд хийгдсэн автобусны дулаан зогсоолуудаа нээлттэй болгох.	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
<b>ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР</b>		
4.	2026 оны Зорилтот жилийн төлөвлөгөөг 1 дүгээр сард багтааж батлуулах	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
5.	ХАСХОМ гаргах албан тушаалтнууд 2026.01.31 өдрийн дотор ХАСХОМ мэдүүлэх	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Эрх бүхий албан тушаалтнууд
6.	Зорилтот жилийн нээлт 1 дүгээр сарын 27-нд зохион байгуулна, бэлтгэлийг хангах	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
7.	2026 оны Байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах 1 дүгээр сарын 27-нд албажуулах	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Нийт байгууллагууд
8.	Эрүүл мэндийн төвд нэн шаардлагатай нарийн мэргэжлийн эмчийн ажлын байр зарлах, нөхөх	Нийгмийн хөгжлийн хэлтэс, Эрүүл мэндийн төв

9.	Хүйтний эрч чангарч байгаатай холбогдуулан ААНБ-ууд инженерийн дэд бүтцийн хэвийн ажиллагаанд тогтмол хяналт тавих	Дүүргийн менежер, Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, нийт байгууллагууд, Дэд бүтцийн байгууллагууд
10.	ААНБ-ууд цахилгааны нөөц эх үүсвэрийн бэлтгэл бэлэн байдлыг хангах	Дүүргийн менежер, Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Дэд бүтцийн байгууллагууд
11.	2025 оны Санхүүгийн аудитын бэлтгэлийн хангах	Санхүү, төрийн сангийн хэлтэс
12.	Зуны тохижилтын ажлын бэлтгэл бэлэн байдлыг 2026 оны 3 дугаар сард багтаан дуусгах	Багахангай Тохижилт ОНӨААТҮГ, Багахангай Гэрэлтүүлэг Ногоон байгууламж ОНӨААТҮГ-ууд

ТАНИЛЦСАН  
ЗАСАГ ДАРГА

А.СҮХБОЛД

ХЯНАСАН  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Б.ОТГОНЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
МЭРГЭЖИЛТЭН

Н.БАТЦЭНГЭЛ